

БАЯН-ОВОО СУМЫН ЕБС 2017 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл
дараах хаягаар харилцана уу:

ТАБ-ын Тэргүүлэх аудитор
Ч. Эрдэнэбаатар
Утас:70562112
Цахимхаяг:

Аудитын менежер:
Д.Оюунтуяа
Утас:70562147
Цахимхаяг:

Аудитор:
Утас:
Цахимхаяг:

ТАБ-ын хаяг: Хэнтий аймаг дахь
Төрийн аудитынгазар
Байршил: Хэнтий аймаг Хэрлэн сум
Сариг баг
Цахим хуудас: www.audit.mn

Өнлөрхаан Итгэл Аудит ХХК
Захирал Б.Маналсүрэн
Утас 70562575, 99059424
Цахим хаяг:
undurkhaanitgel@yahoo.com

Аудитынтайлан

Хавсралт 1: Агуулга

Хавсралт 2: Аудитын гэрчилгээ

Хавсралт 3: Менежментийн захидал

Хавсралт 4: Аудит хийсэн санхүүгийн тайлан

Хавсралт 5: Төсвийн гүйцэтгэлийн тайлан

АГУУЛГА

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Материаллаг байдлын түвшин
6. Дотоод хяналт
7. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
8. Шилэн дансны мэдээлэл
9. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
10. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
11. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:
12. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:
13. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
14. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
15. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтг
16. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
17. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:

Төсвийн тухай хуулийн 8.9.1, Төрийн аудитын тухай хуулийн 15.1.2 дахь заалтыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 18.2 дугаар зүйлд заасан бүрэн эрхийн хүрээнд Баян-Овоо сумын ЕБСургуулийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд ХЭА-2018/23/-СТА-ХАК-ТШЗ аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Баян-Овоо сумын ЕБСургуулийн 2017 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Баян-Овоо сумын ЕБСургуулийн 2017 оны санхүүгийн тайлангийн аудитыг 2018 оны 2 дугаар сарын 07-ноос 2018 оны 2 дугаар сарын 25-ны хооронд хийхээр төлөвлөн Аймгийн аудитын газрын гэрээт Өндөрхаан Итгэл Аудит ХХК-ийн 1 дүгээр багийн аудитор хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

Баян-Овоо сумын ЕБСургууль нь 2017 оны санхүүгийн тайлангаа 2018 оны 2 дугаар сарын 11-нд Өндөрхаан Итгэл Аудит ХХК-д ирүүлсэн байна.

Өндөрхаан Итгэл Аудит ХХК нь аудитыг 2018 оны 2 дугаар сарын 11-нээс 2018 оны 2 дугаар сарын 25-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2018 оны 2 дугаар сарын 25-нд Баян-Овоо сумын ЕБСургуулийн удирдлагад гардуулна.

Байгууллагын хууль, эрх зүйн орчин:

Баян-Овоо сумын ЕБСургуулийн төсвийн захирагч нь “Боловсролын тухай” “Бага дунд боловсролын тухай” Монгол улсын “Төсвийн тухай” “Нягтлан бодох бүртгэлийн тухай” “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай” “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай” “Хөдөлмөрийн тухай” “Төрийн аудитын тухай” “Нийгмийн даатгалын тухай” “ХХОАТ-ын тухай” “Шилэн дансны тухай” хуулиуд болон Засгийн газрын тогтоол, Сангийн сайдын тушаал, бусад холбогдох хуулиудын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна. Тайлант онд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хууль, тогтоомж, түүнд нийцүүлэн гарсан журам, зааварт өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:

Монгол улсын боловсролын тухай хуулийн 4-р зүйлийн 4.1-д Монгол улсын боловсролын зорилго нь иргэдийн оюун ухаан, ёс суртахуун, бие бялдарын чадавхитай, хүмүүнлэг ёсийг дээдлэн сахидаг, бие даан сурах, ажиллах, амьдрах чадвартай болгон төлөвшүүлэхэд оршино” гэж сургалтын байгууллагын зорилтыг тодорхойлсон байна. Монгол улсын Бага дунд боловсролын тухай хуулийн 1-р зүйлийн 1.1, 2-р зүйлийн 2.1-д заасан Бага боловсролын зорилго нь эх хэлний суурь чадамжтай, бүтээлч, сурах арга барилтай монгол хүүхэд төлөвшүүлэх, Суурь боловсролын зорилго нь амьдрах ухаан, шинжлэх ухааны суурь мэдлэг, чадвар эзэмшсэн, бие даан бүтээлчээр суралцах

чадамжтай иргэн төлөвшүүлэх, Бүрэн дунд боловсролын зорилго нь мэдээлэл боловсруулах, шийдвэр гаргах, суралцах чадвар бүхий ирээдүйд эзэмших мэргэжлийн ерөнхий суурь чадамжтай иргэн төлөвшүүлэхэд тус тус оршино” гэсэн заалтуудыг баримтлан ажилладаг.

Тус сургууль нь “Үндэсний бахархал, мэдлэг чадварыг дээдэлж, амьдрах ухаанд суралцсан эерэг хандлагатай иргэнийг төлөвшүүлнэ” гэсэн зорилгын хүрээнд 10 зорилтыг дэвшүүлэн үйл ажиллагаагаа “хангалттай сайн” гэсэн үнэлгээтэй ажилласан байна.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д “Төсвийн байгууллага нь түүний үйл ажиллагааг үр ашигтай удирдлагаар хангаж, ажлын үр дүнг хариуцах үүрэг бүхий төсвийн шууд захирагчтай байна” гэж заасан байна.

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4.18-д “Төсвийн бусад байгууллагын дарга /захирал, эрхлэгч/ тухайн байгууллагын төсвийн шууд захирагч байна” гэж заасны дагуу Баян-Овоо сумын сургуулийн захирал төсвийн захирагчийн үүргийг гүйцэтгэж байна. Баян-Овоо сумын сургуулийн 2017 оны төсвийг Аймгийн төрийн сангаас олгож байна.

Төсвийн шууд захирагчтай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд байгууллагатай холбоотой Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг хэрэгжүүлэн ажиллаж байна. Бусад хууль тогтоомжуудыг байгууллагын эрх зүйн орчин хэсэгт харуулав.

Баян-Овоо сумын ЕБСургуулийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын аргазүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Баян-Овоо сумын ЕБСургуулийн 2017 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс төсвийн захирагчийн удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан горим, сорил 5-г гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад Баян-Овоо сумын ЕБС -ийн санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг өөрсдийн санхүүгийн ажилтан болон мэргэжлийн байгууллагын оролцоотойгоор боловсруулан 2017 оны 10 дугаар сарын 1-нээс эхлэн мөрдөн ажиллаж байна..

Баян-Овоо сумын ЕБСургуулийн санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

Баян-Овоо сумын ЕБСургуулийн санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг санхүү нягтлан бодох бүртгэлийн СТС санхүүгийн програмаар боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн

тайланг гаргасан байна. Энэхүү програм нь үндсэн хөрөнгийн элэгдэл бодоход хүндрэлтэй, СБТайланд бараа материал дутуу тайлагнадаг, мөнгөн хөрөнгийн журналаас худалдан авсан үндсэн хөрөнгийн дүн МГТайланд татагдаггүй. Иймээс санхүүгийн үндсэн тайлангуудад гараар засвар хийдэг дутагдалтай талууд ажиглагдсан.

Материаллаг байдлын түвшин:

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1 хувиар тогтоож, хүлээн зөвшөөрөх алдааны түвшинг 4959,7 мянган төгрөг гэж тооцов.

Дотоод хяналт:

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм. Баян-Овоо сумын ЕБСургуулийн хяналт эрсдэлийг төлөвлөлтийн үед бага гэж тооцсон ба дахин хянахад дотоод хяналт хэвийн байна.

Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:

2017 оны батлагдсан төсвийг сар, улирлын хуваарийн дагуу салбарын яамны Төрийн сангийн харилцах дансаар дамжуулан аймгийн Төрийн сангаас санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавин ажилласан байна.

Баян-Овоо сумын ЕБСургуулийн төсвийн захирагч нь 2017 онд улсын төсвөөс урсгал зардалд 427531,8 мянган төгрөг батлагдсанаас 426731,8 мянган төгрөгийг зарцуулсан ба улсын төсөвт 319,6 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн.

Нэмэлт санхүүжилтээр БСШУСЯ-наас 6000,4 мянган төгрөг, ҮБҮА Орлогоос 6292,1 мянган төгрөг нийт 12292,5 мянган төгрөгийн орлого орж эрх нээлгэж зарцуулсан бөгөөд нэмэлт данснаас 534,2 мянган төгрөг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн.

Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны хуулийн гол зорилт нь улс, орон нутгийн төсөв, улсын болон орон нутгийн өмчийн хөрөнгийн үр ашигтай зарцуулах зорилгоор төсвийн удирдлагын хэрэгжүүлэх шийдвэр, үйл ажиллагааг ил тод нээлттэй, ойлгомжтой байх түүнд олон нийт хяналт тавих мэдээллийн тогтолцоог бүрдүүлэхэд оршино гэж заасан.

Баян-Овоо сумын ЕБСургууль нь шилэн дансны тухай хуулийн 6.1.6, 6.4.3, 6.4.4, 6.4.5, 6.4.6, 6.4.8, 6.4.9 заасан мэдээлэлүүдийг 10-р сард хугацаа хоцроосон байна. Байгууллагын батлагдсан төсөв, төсвийн гүйцэтгэл, санхүүжүүлэх эх үүсвэрийн 1-12 дүгээр сарын мэдээг шивж оруулсан байна. 5 сая төгрөгнөөс дээш дүнтэй орлого, төсөв хөрөнгөтэй холбогдолтой тушаал шийдвэрийг шилэн дансанд мэдээлсэн байна. Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг шалгаж хавсаргав.

Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 7 эрсдлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 7 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Үр дагаврыг тодорхойлж чадвал: Багш нарын ээлжийн амралтын дундаж, амралтын хоногийг буруу тооцож, амралтын мөнгийг дутуу олгосон, дутуу олгосноо буцаан олгохдоо дахин буруу тооцож илүү суутгасан, 3 багшийн ажилласан хугацааны ээлжийн амралтын цалинг дутуу бодож олгосон, ажиллагсдаас суутгах НДШ, ХХОАТ, сахилгын

шийтгэл зэргийг буруу бодож цалинг олгосон, малын хөдөлгөөний тайланг сүүлийн 2 жил тайлагнаагүй, төлбөрийн хүсэлт дугааргүй зэрэг нь санхүүгийн тайлангийн иж бүрэн байх, үнэн зөв байдал, толилуулга ба илчлэл гэсэн батламж мэдэгдлийн шаардлагыг хангахгүй байна.

Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар:

Баян-Овоо сумын ЕБСургуулийн 2017 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний мөнгөн хөрөнгө, цалин, НДШ, ХХОАТ, бараа материал, үндсэн хөрөнгө, орлого, зардал, авлага өглөг зэрэг дансанд ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцоолуудыг түүвэрчлэн нарийвчилсан горим, сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/

Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Аудитын явцад материаллаг бус хэмжээний дараах алдаа илэрсэн байна. Үүнд:

1. Багш ажилчдын ээлжийн амралтын дундаж цалинг буруу бодож олгосон 31 хүнд 2457569 төгрөгийн цалин илүү, 7 хүнд 2202240 төгрөгийн цалин дутуу олгосон байна. Суутгалыг буруу тооцоолж 721.1 мянган төгрөгийг илүү суутгасан нь Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын 2000 оны 166 тоот тушаалын 2-р хавсралтын 7-р зүйлд заасан тухайн ажлын жилийн ээлжийн амралтын олговрыг тодорхойлохдоо өмнөх ажлын жилийн ээлжийн амралтын олговрыг тооцоход оруулсан хугацааны дундаж цалин хөлсийг давхардуулан оруулж тооцохгүй гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Дээрх зөрчлийг давтан гаргахгүй байх талаар зөвлөмж өгөх

2. Илүү олгосон ээлжийн амралтын цалинг суутгахдаа авлага үүсгэлгүй үндсэн цалинг шууд бууруулсан. Мөн суутгалыг буруу тооцоолж 2 багшийн цалингаас 268,1 мянган төгрөгийг дутуу суутгасан нь Монгол улсын Засгийн газрын 2014 оны 75 тоот тогтоолоор батласан цалингийн жишгийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Дээрх зөрчилд төлбөрийн акт тогтоох

3. 3 багшийн ажилласан хугацааны ээлжийн амралтын 2339,4 мянган төгрөгийн цалинг дутуу бодож олгосон нь Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын 2000 оны 166 тоот тушаалын 1-р хавсралтын 1.14-д заасан Хэрвээ ажилтан ажлаас халагдах тухай асуудал тавигдаагүй байгаа бол түүний ээлжийн амралтыг ажилласан хугацаанд нь ноогдуулж биш ажлын бүтэн жилээр тооцож олгоно гэснийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Дээрх зөрчлийг давтан гаргахгүй байх талаар зөвлөмж өгөх

4. Д.Алтанцэцэг, С.Ганэрдэнэ нарын цалингаас 54,9 мянган төгрөгийн НДШ дутуу, ХХОАТ илүү суутгаж цалинг олгосон нь НД-ын тухай Хуулийн 17 дугаар зүйлийн 1 "Ажил олгогч болон энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан даатгуулагч нь шимтгэл төлөх талаар дор дурдсан үүрэг хүлээнэ", 17 дугаар зүйлийн 1.1 дэх заалт "хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох

шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх" заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Дээрх зөрчлийг давтан гаргахгүй байх талаар зөвлөмж өгөх

5. Мөнхболд Уранцэцэг нарын ажил тасалсан хоногийг хасаагүй 52.4 мянган төгрөгийн цалин бодсон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.7-д " Аж ахуйн нэгж байгууллагын татвар, төлбөр, хураамж, шимтгэлийн тооцооллыг шалгах, тэдгээрт хяналт тавих, мэргэжлийн үйлчилгээний зөвлөгөө туслалцаа авах" гэж заасныг зөрчиж байна.

Шийдвэрлэсэн: Дээрх зөрчлийг давтан гаргахгүй байх талаар зөвлөмж өгөх

6. 1 ажилтанд 21.0 мянган төгрөгийн ХХОАТ-ын хөнгөлөлт дутуу эдлүүлсэн нь ХХОАТ-ын тухай бусад хуулийн 11 дүгээр зүйлийн 11.6 'Үндсэн ажлын газраас бусад хуулийн этгээд болон хувь хүнтэй байгуулсан гэрээний үндсэн дээр ажил үүргээ гүйцэтгэж авсан хөдөлмөрийн хөлс, шагнал, нэмэгдэл тэдгээртэй адилтгах бусад орлого-д ноогдох жилийн албан татварт 84000 төгрөгийн албан татварын хөнгөлөлт үзүүлнэ' гэсэн заалтыг зөрчиж байна..

Шийдвэрлэсэн: Дээрх зөрчлийг давтан гаргахгүй байх талаар зөвлөмж өгөх

7. Галч Батчулууны сахилгын шийтгэлийн үндсэн цалингаас суутгах 2 сарын 40 % буюу 149.5 мянган төгрөгийг суутгаагүй нь Сургуулийн захирлын тушаалыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Дээрх зөрчлийг давтан гаргахгүй байх талаар зөвлөмж өгөх

Залруулагдаагүй алдаануудынталаарх тайлбар:

Тус байгууллагын санхүүгийн тайлангийн аудитаар 19434,4 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрсэн ба үүнээс 15828,0 мянган төгрөгийн алдааг залруулж, 3606,4 мянган төгрөгийн материаллаг бус 6 алдааг санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөлөл байхгүй тул залруулах шаардлагагүй гэж үзлээ.

Анхаарал татахуйц бусад чухал асуудал:

Энэхүү аудитын явцад анхаарал татахуйц чухал асуудал илрээгүй.

Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:

Баян-Овоо сумын ЕБСургуулийн 2017 оны санхүүгийн тайлангийн аудитын явцад яригдсан асуудлууд болон менежментийн захидлаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг хянан үзнэ. Мөн аудитын явцад мөшгөн шалгаж амжаагүй малын хөдөлгөөний тайлан, малын тооллогыг хянаж үзэх шаардлагатай.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Баян-Овоо сумын ЕБСургуулийн 2017 оны санхүүгийн тайлангийн аудитаар залруулагдаагүй 3606,4 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрсэнээс 268,1 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 3338,3 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж өгөв.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:

Баян-Овоо сумын ЕБСургуулийн 2016 оны санхүүгийн тайланд аудит хийгдээгүй байна.

Зөрчилгүй санал дүгнэлт

Баян-Овоо сумын ЕБСургуулийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө /өмчийн өөрчлөлт, мөнгөн

гүйлгээболон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүтгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлэн Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн бодитой шудрага илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Аудит хийгдсэн санхүүгийн тайлан, менежментийн захидал, аудитын гэрчилгээг тус тус хавсаргав.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ч.Эрдэнэбаатар

АУДИТЫН МЕНЕЖЕР

Д.Оюунтуяа

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР

Б.Баярмаа 2018.02.25





**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

23119 Хэнтий аймаг, Хэрлэн сум, Сариг баг
Утас: 70-56-21-47, Факс: 70-56-21-12
E-mail: khentii@audit.gov.mn

2018.02.28 № 06162
танай _____ -ны № _____ -т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8.9.1-д заасны дагуу Баян-Овоо сумын ЕБС-ийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Баян-Овоо сумын ЕБС-ийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Баян-Овоо сумын ЕБС-ийн 2017 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Баян-Овоо сумын ЕБСургууль нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

0500639

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭРДЭНЭБААТАР

**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТЫН ТАЙЛАГНАЛЫН
ҮЕ ШАТНЫ АЖЛЫН ХЯНАЛТЫН ХУУДАС**

Аудитын нэр: Баяновоо сумын ЕБСургуулийн 2017 оны санхүүгийн

тайлан

Аудитын код: ХЭА/2018/231-СТА-ХАК-ТШЗ

Аудитын багийн нэр: Өндөрхаан Итгэл аудит ХХК



Тайлант жил : 2017 он

№	Аудитыг тайлагнах шатанд бүрдүүлэх баримтын нэр	Хяналт хийсэн огноо		Тайлбар
		Анхан шатны хяналт	Хоёрдах шатны хяналт	
1	Аудитын тайлан	Засах		Хэргийг засах
2	Ерөнхий аудиторроор гарын үсэг зуруулахаар бэлтгэсэн Аудитын гэрчилгээ	Төмөөр болон		
3	Менежментийн захидал	Товч болон		
	Аудит хийгдсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан	Т/Т-н тайланг засах ✓		
4	Санхүүгийн тайланд аудит хийлгэх тухай байгууллагын албан бичиг болон санхүүгийн тайлан	Хийнэ		
5	Акт, албан шаардлагын төсөл			Актын төсөл тэмдэг авах
6	Хянан удирдах ажилтнуудын үүргийн хэрэгжилт			

Бэлтгэсэн: Аудитор *Б.Морь*

Анхан шатны хяналт хийсэн аудитын менежер :

Хоёрдах шатны хяналт хийсэн Тэргүүлэх аудитор:



- Аудитаар илрэн дорлоогийг товчболонг үзвэл асуудалтайг нь болгох.
- Ур дүнгийн тайланг чух төлбөргүй лавран дараа нь болон засаагүй бол.
- Төсвийн үнэмлэхүй тайланг тохируулаа хийнэ.

БАЯН-ОВОО СУМЫН ЕБС-ИЙН 2017 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Менежментийн захидал

Тэргүүлэх ач холбогдол №1 зүйлс:

Асуудал 1
Цалин
Асуудал 2
Цалин
Асуудал 3
Цалин
Асуудал 4
Цалин
Асуудал 5
Цалин
Асуудал 6
Цалин

2018 оны 2 дугаар сар

Менежментийн захидал

Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газар аудитын явцад илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг Баян-Овоо сумын ЕБС-ийн удирдлагад зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал, горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг өглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга АОУС-ын дагуу хийгддэг ТАБ-ын аудитын горимоос урган гарсан болно. Бидний хэрэгжүүлсэн горим, сорил нь санхүүгийн тайлангийн санал дүгнэлт гаргахад зориулагдсан.

Тиймээс аудитын зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний үнэлэлт, дүгнэлтийг тусгаж байгаа болно.

Төрийн аудитын байгууллага энэхүү зөвлөмжийг та бүхний бүртгэл, тайлагнал, хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилготой бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан Баян-Овоо сумын ЕБС-ийн санхүүгийн холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Асуудал1: Цалин
Ажиглалт 1

Багш ажилчдын ээлжийн амралтын дундаж цалинг буруу бодож олгосон .31хүнд 2457569 төгрөгийн цалин илүү, 7 хүнд 2202240 төгрөгийн цалин дутуу олгосон байна. Энэ нь Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын 2000 оны 166 тоот тушаал болон санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал, хэмжилт, толилуулга ба тодруулга гэсэн батламж мэдэгдлийг бүрэн хангахгүй байна.

Тэргүүлэх ач холбогдол №1

Зөвлөмж

Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын 2000 оны 166 тоот тушаалын 2-р хавсралтын 7-р зүйлд заасан тухайн ажлын жилийн ээлжийн амралтын олговрыг тодорхойлохдоо өмнөх ажлын жилийн ээлжийн амралтын олговрыг тооцоход оруулсан хугацааны дундаж цалин хөлсийг давхардуулан оруулж тооцохгүй гэсэн заалтыг мөрдөж ажиллах

Эрсдэлүүд

Санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал,
хэмжилт, үнэлгээ зэрэг батламж мэдэгд-
лийг зөрчих эрсдэлтэй

Төсвийн захирагчийн хариу

Асуудал 2: Цалин

Ажиглалт 2

3 багшийн ажилласан хугацааны ээлжийн амралтын 2339362 төгрөгийн цалинг дутуу бодож олгосон. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйл болон санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал, хэмжилт, толилуулга ба тодруулга гэсэн батламж мэдэгдлийг бүрэн хангахгүй байна.

Тэргүүлэх ач холбогдол №1

Зөвлөмж

Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын 2000 оны 166 тоот тушаалын 1-р хавсралтын 1.14-д заасан Хэрвээ ажилтан ажлаас халагдах тухай асуудал тавигдаагүй байгаа бол түүний ээлжийн амралтыг ажилласан хугацаанд нь ноогдуулж биш ажлын бүтэн жилээр тооцож олгоно гэснийг мөрдөж ажиллах

Эрсдэлүүд

Санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал, хэмжилт, үнэлгээ зэрэг батламж мэдэгдлийг зөрчих эрсдэлтэй

Төсвийн захирагчийн хариу

Асуудал 3: Цалин

Ажиглалт 3

1 ажилтанд 21000 төгрөгийн ХХОАТ-ын хөнгөлөлт дутуу эдлүүлсэн. Энэ нь сургуулийн захирлын тушаал болон санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал, хэмжилт, толилуулга ба тодруулга гэсэн батламж мэдэгдлийг бүрэн хангахгүй байна.

Тэргүүлэх ач холбогдол №1 Зөвлөмж

ХХОАТ-ын тухай бусад хуулийн 11 дүгээр зүйлийн 11.6 'Үндсэн ажлын газраас бусад хуулийн этгээд болон хувь хүнтэй байгуулсан гэрээний үндсэн дээр ажил үүргээ гүйцэтгэж авсан хөдөлмөрийн хөлс, шагнал, нэмэгдэл тэдгээртэй адилтгах бусад орлого-д ноогдох жилийн албан татварт 84000 төгрөгийн албан татварын хөнгөлөлт үзүүлнэ' гэсэн заалтыг мөрдөж ажиллах

Эрсдэлүүд

Санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал, хэмжилт, үнэлгээ зэрэг батламж мэдэгдлийг зөрчих эрсдэлтэй

Төсвийн захирагчийн хариу

Асуудал 4: Цалин

Ажиглалт 4

Галч Батчулууны сахилгын шийтгэлийн үндсэн цалингаас суутгах 2 сарын 40% 149436 төгрөгийг суутгаагүй. Энэ нь сургуулийн захирлын тушаал болон санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал, хэмжилт, толилуулга ба тодруулга гэсэн батламж мэдэгдлийг бүрэн хангахгүй байна.

Тэргүүлэх ач холбогдол №1 Зөвлөмж

Сургуулийн захирлын тушаалыг мөрдөж ажиллах

Эрсдэлүүд

Санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал, хэмжилт, үнэлгээ зэрэг батламж мэдэгдлийг зөрчих эрсдэлтэй

Төсвийн захирагчийн хариу

Асуудал 5: Цалин

Ажиглалт 5

Д.Алтанцэцэг, С.Ган-Эрдэнэ нарын цалингаас 54929 төгрөгийн НДШ суутгаагүй. ХХОАТ илүү суутгасан. Энэ нь сургуулийн захирлын тушаал болон санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал, хэмжилт, толилуулга ба тодруулга гэсэн батламж мэдэгдлийг бүрэн хангахгүй байна.

Тэргүүлэх ач холбогдол №1

Зөвлөмж

НД-ын тухай Хуулийн 17 дугаар зүйлийн 1 " Ажил олгогч болон энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан даатгуулагч нь шимтгэл төлөх талаар дор дурдсан үүрэг хүлээнэ", 17 дугаар зүйлийн 1.1 дэх заалт "хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх" заалтыг мөрдөж ажиллах

Эрсдэлүүд

Санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал, хэмжилт, үнэлгээ зэрэг батламж мэдэгдлийг зөрчих эрсдэлтэй

Төсвийн захирагчийн хариу

Асуудал 6: Цалин

Ажиглалт 6

Мөнхболд Уранцэцэг нарын ажил тасалсан хоногийг хасаагүй 52416 төгрөгийн цалин бодсон. Энэ нь сургуулийн захирлын тушаал болон санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал, хэмжилт, толилуулга ба тодруулга гэсэн батламж мэдэгдлийг бүрэн хангахгүй байна.

Тэргүүлэх ач холбогдол №1 Зөвлөмж

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.7-д "Аж ахуйн нэгж байгууллагын татвар, төлбөр, хураамж, шимтгэлийн тооцооллыг шалгах, тэдгээрт хяналт тавих, мэргэжлийн үйлчилгээний зөвлөгөө туслалцаа авах мөрдөж ажиллах

Эрсдэлүүд

Санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал, хэмжилт, үнэлгээ зэрэг батламж мэдэгдлийг зөрчих эрсдэлтэй

Төсвийн захирагчийн хариу

Бэлтгэсэн:

Аудитор

Хянасан:

Тэргүүлэх аудитор

Аудитын менежер



Б.Баярмаа

Ч.Эрдэнэбаатар

Д.Оюунтуяа